



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 7201

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн ахлагч: З.Цэцэгмаа (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Д.Уранчимэг (Ерөнхий нягтлан бодогч)

Д.Мөнхбат (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)


Б.Бямбасүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Л.Цэдэв (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2. Холбогдох журмын дагуу 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэхийг Үнэлгээний багийн ахлагч (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТБАЯР



622301203

D:Alban bichig: Zahirami 2023